



ХУРААНГУЙ, ЗАВСРЫН ҮЕИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2023 болон 2024 оны 6 сарын 30-ны өдөр дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

*(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)*

Удирдлага бэлтгэв – Уншигчдад хүргүүлэх мэдэгдэлтэй танилцана уу

УНШИГЧДАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

National Instrument 51-102 Мэдээллийн ил тод байдлын үүрэг хариуцлага, 4-р хэсэг, 4.3 (3) а-д заасны дагуу хэрэв завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитор хянан, баталгаажуулаагүй тохиолдолд энэхүү мэдэгдлийг хавсаргах үүрэг хүлээдэг. Энэхүү аудитаар баталгаажаагүй завсрын үеийн нэгтгэсэн хураангуй тайланг Компанийн удирдлага бэлтгэсэн. Удирдлага нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2023 оны 12 сарын 31 болон 2024 оны 6 сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланг нэгтгэн, 2024 оны 6 сарын 30-ны өдөр дуусгавар болсон гурав болон зургаан сарын нийт алдагдал, эздийн өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний мэдээллийг боловсруулсан. Компанийн хараат бус аудитор нь 2023, 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх, хянах болон ямарваа нэгэн байдлаар мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулаагүй болно. Уншигчдын зорилготой нийцэхгүй байх магадлалтай тул энэхүү мэдэгдлийг хүргүүлэв.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

	Тодруулга	2024.06.30	2023.12.31
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 3,027,494	\$ 4,349,599
Дансны авлага		135,848	6,722
Урьдчилж төлсөн авлага		81,891	1,455,652
Эргэлтийн хөрөнгийн дүн		3,245,233	5,811,973
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	4	51,643,868	51,248,731
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	5	2,252,312	1,961,506
Үндсэн хөрөнгө		42,967	21,155
Хөрөнгө ашиглах эрх		4,896	19,581
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		53,944,043	53,250,973
Нийт хөрөнгийн дүн		\$ 57,189,276	\$ 59,062,946
Өр төлбөр ба эздийн өмч			
Арилжаа болон бусад өглөг		\$ 369,921	\$ 163,212
Түрээсийн өглөг		5,824	22,939
Богино хугацаат өр төлбөр		375,745	186,151
Нийт өр төлбөрийн дүн		375,745	186,151
Эздийн өмч			
Хувьцаат капитал	7	\$ 159,393,368	\$ 158,086,286
Нэмж төлөгдсөн капитал	7	31,245,578	30,147,989
Хуримтлагдсан ба бусад алдагдал		(770,346)	(849,598)
Алдагдал		(133,055,069)	(128,507,882)
Эздийн өмчийн дүн		56,813,531	58,876,795
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		\$ 57,189,276	\$ 59,062,946

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 6)

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөх ("ТУЗ")-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан "Кеннет МакДоналд"

ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан "Лэйтон Крофт"

ТУЗ-ийн гишүүн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн (ашиг) алдагдлын дэлгэрэнгүй тайлан
(Канад доллараар)
(Аудитаар баталгаажуулаагүй)

Notes	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар		
	2024	2023	2024	2023	
		Тохируулсан (Тодруулга 12)		Тохируулсан (Тодруулга 12)	
Үйл ажиллагааны зардал					
Хайгуул, үнэлгээний зардал	8	\$ 596,590	\$ 478,599	\$ 1,379,746	\$ 545,426
Ерөнхий ба удирдлагын зардал	9	667,030	1,391,454	3,444,618	1,971,565
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал		1,263,620	1,870,053	4,824,364	2,516,991
Хараат компанид оруулсан хөрөнгө					
оруулалтаас үүдсэн алдагдал	4	644,607	696,325	901,623	1,260,531
Санхүүгийн орлого		(36,996)	(71,569)	(86,014)	(148,678)
Хүүгийн зардал		136	671	404	1,477
Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан (ашиг) алдагдал		(2,553)	12,101	(22,453)	16,196
ашиг	4	-	-	-	(6,544,863)
Хараат компанийн хөрөнгө оруулалтын хорогдуулалтаас үүссэн ашиг	4	-	-	(1,070,737)	-
Цэвэр (ашиг) алдагдал		\$ 1,868,814	\$ 2,507,581	\$ 4,547,187	\$ (2,898,346)
Бусад дэлгэрэнгүй алдагдал:					
Гадаад дахь охин компанийн хөрвүүлснээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү		(17,557)	164,665	(79,252)	639,065
Охин компанийн хяналт шилжсэнээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү	4	-	-	-	(5,110,896)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		(17,557)	164,665	(79,252)	(4,471,831)
Нийт дэлгэрэнгүй (ашиг) алдагдал		\$ 1,851,257	\$ 2,672,246	\$ 4,467,935	\$ (7,370,177)
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал		\$ 0.00	\$ 0.01	\$ 0.01	\$ (0.01)
Гаргасан болон эргэлтэд буй хувьцааны					
жигнэсэн дундаж тоо		346,735,996	344,371,805	345,861,866	344,336,288
Хорогдуулсан нийт хувьцааны					
жигнэсэн дундаж тоо		346,735,996	344,371,805	345,861,866	344,336,288

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

	Тодруулга	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
2024.01.01-ний үлдэгдэл		344,888,176	\$ 158,086,286	\$ 30,147,989	\$ (849,598)	\$ (128,507,882)	\$ 58,876,795
Тайлант үеийн нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(4,547,187)	(4,547,187)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	79,252	-	79,252
Хэрэгжүүлсэн опцион	7	2,660,000	876,900	(270,900)	-	-	606,000
Хэрэгжүүлсэн варрант	7	883,330	430,182	(32,683)	-	-	397,499
Хувьцаанд суурилсан урамшуулал		-	-	1,401,172	-	-	1,401,172
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		3,543,330	1,307,082	1,097,589	-	-	2,404,671
2024.06.30-ны үлдэгдэл		348,431,506	\$ 159,393,368	\$ 31,245,578	\$ (770,346)	\$ (133,055,069)	\$ 56,813,531
					Тохируулсан (Тодруулга 12)	Тохируулсан (Тодруулга 12)	
2023.01.01-ний үлдэгдэл		344,300,376	\$ 157,880,069	\$ 28,727,197	\$ (5,952,986)	\$ (129,029,925)	\$ 51,624,355
Тайлант хугацааны нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	2,898,346	2,898,346
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	4,471,831	-	4,471,831
Хэрэгжүүлсэн опцион	7	100,000	31,400	(11,400)	-	-	20,000
Хувьцаанд суурилсан урамшуулал		-	-	1,210,225	-	-	1,210,225
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		100,000	31,400	1,198,825	-	-	1,230,225
2023.06.30-ны үлдэгдэл		344,400,376	157,911,469	29,926,022	(1,481,155)	(126,131,579)	\$ 60,224,757

Дагалдах тодруулгауд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

Тодруулга	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2024	2023 Тохируулсан (Тодруулга 12)	2024	2023 Тохируулсан (Тодруулга 12)
Үндсэн үйл ажиллагаан мөнгөн гүйлгээ				
Цэвэр алдагдал	\$ (1,868,814)	\$ (2,507,581)	\$ (4,547,187)	2,898,346
Мөнгөн бус гүйлгээнүүд				
Элэгдэл, хорогдол	10,255	9,215	19,278	18,595
Хувьцаанд суурилсан урамшуулал	7 361,926	1,152,993	1,401,172	1,210,225
Санхүүгийн орлого	(36,996)	(71,569)	(86,014)	(148,678)
Мөнгөн бус гадаад валют	(2,553)	12,101	(22,453)	16,196
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас үүссэн алдагдал	4 644,607	696,325	901,623	1,260,531
Охин компанийн хяналт шилжсэнээс үүссэн ашиг	4 -	-	-	(6,544,863)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын хорогдолтын ашиг	4 -	-	(1,070,737)	-
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	192,762	840,189	1,224,984	(180,372)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(698,813)	131,673	(2,179,334)	(1,470,020)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Опцион хэрэгжүүлснээс олсон орлого	7 402,000	20,000	606,000	20,000
Варрант хэрэгжүүлснээс олсон орлого	7 397,499	-	397,499	-
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт	(8,625)	(8,088)	(17,115)	(16,042)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	790,874	11,912	986,384	3,958
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал	5 (73,996)	(948,594)	(214,240)	(948,594)
Үндсэн хөрөнгийн зардал	(2,476)	-	(26,206)	-
Хүүгийн орлого	36,996	71,569	86,014	148,678
Охин компанийг нэгтгэлээс хассанаас үүдсэн мөнгөн хөрөнгийн алдагдал	-	-	-	(254,049)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(39,476)	(877,025)	(154,432)	(1,053,965)
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	2,837	(8,099)	25,277	(12,370)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт	55,422	(741,539)	(1,322,105)	(2,532,397)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд	2,972,072	5,630,742	4,349,599	7,421,600
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст	\$ 3,027,494	\$ 4,889,203	\$ 3,027,494	\$ 4,889,203

Дагалдах тодруулгууд нь хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад Улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуулын үйл ажиллагааг Монгол Улсад эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь хараат компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшдэг Монгол Улсын Баянхонгор аймагт орших Баянхөндий алтны төсөл юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр “ERD”, Монголын Хөрөнгийн Бирж дээр “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

2. Тайлангийн үндэслэл

2024 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын аудитаар баталгаажуулагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг (“Хураангуй, завсрын үеийн санхүүгийн тайлан”) Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (“НББОУС”) 34 - завсрын санхүүгийн тайлагналын дагуу боловсруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлан нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулагдсан 2023 оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан (“Жилийн эцсийн санхүүгийн тайлан”)-тай хамтад нь танилцах шаардлагатай.

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тайлагнахыг 2024 оны 8 дугаар сарын 7-ны өдөр ТУЗ зөвшөөрсөн.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд

2024 оны 1 дүгээр сарын 1-ээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг холбогдох шилжилтийн заалтуудын дагуу хийсэн.

НББОУС 1 – Санхүүгийн тайлангийн толилуулга

2022 оны 10-р сард НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгад өөрчлөлт оруулан, өр төлбөрийн ангиллыг илүү ерөнхий болгосон. Нэмэлт өөрчлөлтөөр өр төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах нь өр төлбөрийг барагдуулах эрхийг хэрэгжүүлэх хүлээлтээс ялгаатай нь тайлант хугацааны эцэст үүссэн эрхээс хамаарна гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр төлбөр тооцоо нь харилцагч тал руу бэлэн мөнгө, өмчийн хэрэгсэл, бусад хөрөнгө болон үйлчилгээг шилжүүлэхийг хэлнэ гэж тодотгосон. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой суурь өөрчлөлтүүдийг оруулсан бөгөөд Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

4. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

2023 оны 1 сарын 10-нд Компани нь Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсныг мэдээлсэн. Стратегийн түншлэлийн үндсэн нөхцөлүүдийг доор дурдав:

- ММС нь гурван үе шаттайгаар 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)-ын 50%-тай тэнцэх хувьцааг хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг хөрвөх үед эзэмшинэ.
- Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 5 км-ийн талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авах нөхцөлтэй.

2023 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн хувьцааны 100 хувийг эзэмшиж байсан ч стратегийн түншлэлийн гэрээний засаглалын зарим заалтуудын дагуу Эрдэнэ Монгол ХХК-ийн тодорхой үйл ажиллагааг Эрдэнэ Ресурс дангаар удирдах эрхийг хязгаарласан. 2023 оны 1-р сарын 10-ны өдөр Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтыг хуваан, хөрөнгө,

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

өр төлбөрийг бүртгэхийг зогсоосон. Гэсэн хэдий ч удирдлагын зүгээс Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн шийдвэр гаргах үйл явцад ихээхэн нөлөө үзүүлж байгааг харгалзан энэ өдрөөс эхлэн хөрөнгө оруулалтыг тооцохдоо эздийн өмчийн аргыг ашиглаж эхэлсэн.

Компани нь ММС-ийн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн тооцоолол буюу зах зээлийн оролцогчдын харилцан тохиролцооны үндсэн дээр, Эрдэнэ Монгол дахь хөрөнгө оруулалтын эзлэх хувийн бодит үнэ цэнийг 53,527,101 доллар гэж тооцсон. Үр дүнд нь 2023 оны 6-р сарын 30-аар дуусгавар болсон 6 сарын нэгдсэн орлогын нэгдсэн тайланд хяналт алдсанаас үүдсэн 5,110,896 долларын гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүг хасч 6,544,863 долларын ашиг тусгагдсан.

Дараах хүснэгтүүдэд Эрдэнэ Монголд оруулсан хөрөнгө оруулалтын санхүүгийн мэдээллийг 2023 оны 1-р сарын 10-ны өдрийн байдлаар (тайлангаас хасахаас өмнөх байдлаар) хураангуйлан харуулав. Доорх дүн нь компани хоорондын хасалтаас өмнөх дүн:

	1 сарын 10 2023
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 254,049
Дансны авлага	69,558
Бусад	43,236
Эргэлтийн хөрөнгө	366,843
Богино хугацаат өр төлбөр	(1,145,712)
Эргэлтийн хөрөнгийн дүн	(778,869)
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	Тодруулга 5 42,130,165
Үндсэн хөрөнгө	520,046
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	\$ 42,650,211
Нийт хөрөнгийн дүн	\$ 41,871,342

2024 оны 1 сарын 23-нд хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийг хөрвүүлсэнтэй холбогдуулан Эрдэнэ Монгол ХХК нь 50%-тай тэнцэх хувьцааг нэмж гарган, ММС-г хувь эзэмшигчээр бүртгэсэн. ММС нь Эрдэнэ Монголын хувьцааг захиалсан өдөр компани нь хөрвөх нөхцөлтэй өрийн бичгээр дамжуулан ММС-ийн Эрдэнэ Монголд оруулсан хөрөнгө оруулалтаас хамааруулж тооцсон Эрдэнэ Монголд үлдсэн \$1,296,760 долларын хөрөнгө оруулалтыг бууруулсны ашгийг хүлээн зөвшөөрсөн. 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд компанийн хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хураангуйг доор харуулав.

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, 2023.12.31	\$ 51,248,731
Хараат компанийн хяналт алдагдлаас үүссэн алдагдлын хувь 2024.01.23	(26,250)
2024.01.23-ны байдлаар тусгагдах ашиг	1,296,760
Хараат компанийн хяналт алдагдлаас үүссэн алдагдлын хувь 2024.01.23-ээс эхлэж	(875,373)
2024.03.31-ны байдлаар хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	\$ 51,643,868

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

5. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

	Баянхөндий	Алтан нар	Улаан	Зуун мод ба бусад	Нийт
2024.01.01 үлдэгдэл	\$ -	\$ -	\$ -	\$ 1,961,506	\$ 1,961,506
Нэмэгдэл	-	-	-	214,240	214,240
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	-	-	-	76,566	76,566
2024.06.30	\$ -	\$ -	\$ -	\$ 2,252,312	\$ 2,252,312
2023.01.01 үлдэгдэл	\$ 36,183,734	\$ 4,257,954	\$ 1,688,477	\$ 923,991	\$ 43,054,156
Санхүүгийн тайлангийн хасалт (Тодруулга 4)	\$ (36,183,734)	\$ (4,257,954)	\$ (1,688,477)	-	\$ (42,130,165)
Нэмэгдэл	-	-	-	1,043,280	1,043,280
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	-	-	-	(5,765)	(5,765)
2023.12.31	\$ -	\$ -	\$ -	\$ 1,961,506	\$ 1,961,506

Монгол Улс дахь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 жилээр 2 удаа сунгах боломжтой.

2023 оны 1-р сарын 10-аас эхлэн Баянхөндий, Алтан нар, Улаан тусгай зөвшөөрөлд хийсэн хайгуул, үнэлгээний ажлуудыг тухайн өдрөөс эхлэн хараат компанид хийсэн хөрөнгө оруулалт хэсэгт тайлагнана. Тодруулга 4-өөс дэлгэрэнгүй танилцана уу.

Зуун Мод зэс молибденийн төсөл ба бусад

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт 6041 га талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. 2021 оны эцэст Компани түүхий эдийн үнийн өсөлттэй холбогдуулан энэхүү төслийн стратеги болон эдийн засгийн үнэлгээг хийсэн нь төслийн үр ашгийг баталгаажуулсан. Хайгуулын хөтөлбөрөөр порфирийн томоохон ордын эрдэсжилтийг өргөжүүлж, төслийн эдийн засгийн өгөөжийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх боломжтой болов.

6. Гэрээгээр хүлээсэн үүрэг

Компани батлан дааж, Эрдэнэ Монголын эзэмшиж буй Алтан нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндстормд төлөх үүрэг хүлээсэн. Сэндсторм нь дээрх тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой татгалзах эрх эдлэх нөхцөлтэй.

Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR төлбөрийг Сэндбокс Роялти (Sandbox Royalties Corp.)-д төлөх үүрэгтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын тодорхой шатанд хүрснээр тодорхой хувийг эргэн худалдан авах эрх үүснэ.

7. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Варрант

2023, 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын байдлаар варрантын мэдээллийг доор харуулав:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

	2024.06.30		2023.06.30	
	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
1 сарын 1-ний байдлаар	25,264,122	\$ 0.42	25,264,122	\$ 0.42
Хэрэгжүүлсэн	(883,330)	0.45	-	-
6.30-ны байдлаар	24,380,792	\$ 0.42	25,264,122	\$ 0.42
6.30-ны байдлаар хэрэгжих боломжтой	24,380,792	\$ 0.42	25,264,122	\$ 0.42

2024 оны 6 сарын 30-ны байдлаар 883,330 варрантыг жигнэсэн дундаж үнэ нь \$0.45-аар хэрэгжүүлж, \$397,499-ын орлого төвлөрүүлсэн (2023 он – 0 варрант хэрэгжүүлсэн). 2024 оны 6 сарын 30-ны байдлаар жигнэсэн дундаж үнэ нь \$0.45-аар хэрэгжүүлэх боломжтой 11,320,340 варрантын хугацаа дууссан. Жигнэсэн дундаж үнэ нь \$0.40-аар хэрэгжүүлэх боломжтой 13,060,452 варрантын хугацаа 2024 оны 12 сард хугацаа нь дуусна.

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон Залгамж халааны төлөвлөгөө

2023 оны 6 сарын 22-ны өдөр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр” (ХСУБХ буюу Omnibus plan) баталсан. ХСУБХ нь опцион (“Опцион” буюу “Options”), хязгаарлалт бүхий хувьцааны нэгж (“ХБХН” буюу “RSUs”) гүйцэтгэлд суурилсан хувьцааны нэгж (“ГСХН” буюу “PSUs”) ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSUs”) зэрэг хувьцаанд суурилсан урамшууллыг харьцангуй уян хатан байдлаар компани болон охин компаниудын захирал зөвлөхүүд, ажилтнуудад олгон, урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ. ХСУБХ нь батлагдсанаар Залгамж халааны төлөвлөгөө болох хувьцаанд суурилсан опционы төлөвлөгөө, ИОХЭ-ийн төлөвлөгөөг орлоно. Тус төлөвлөгөөнүүдийн дагуу олгогдсон урамшуулал нь хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болтол хүчинтэй.

ХСУБХ нь хувьсах төлөвлөгөө бөгөөд тус хөтөлбөрийн дагуу олгосон энгийн хувьцааний тоо хэмжээ нь (Залгамж халааны төлөвлөгөөгөөр олгосон урамшууллыг багтаасан) Компанийн гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны нийт хэмжээний 10%-иас хэтрэхгүй байх ёстой.

2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компани хувьцаанд суурилсан урамшууллын \$1,401,172 зардлыг нэгтгэсэн (ашиг) алдагдалд зарлагдсан (2023 – \$1,210,225) ба ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон опцион болон ИОХЭ-ийн бодит үнэлгээг тусгасан. ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон урамшууллын дэлгэрэнгүй мэдээллийг дор харуулав:

Хувьцааны опцион

Компани нь хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнуудад компанийн хувьцааг худалдан авах боломж бүхий опционыг олгодог. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Одоогоор хэрэгжүүлэх боломжтой опцион нь хөтөлбөрийн нөхцөлүүдийн дагуу олгогдсон.

2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд олгогдсон опцион нь хайгуулын зардал болон ерөнхий, захиргааны зардалд \$939,500-аар үнэт цаасанд суурилсан урамшууллын хэлбэрээр тусгагдсан (2023 – \$1,078,275). 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд жигнэсэн дундаж үнэ нь \$0.23-аар үнэлэгдсэн, нийт үнэлгээ нь \$606,000 бүхий 2,660,000 опцион хэрэгжиж, 315,000 опционы хугацаа дууссан (2023 – 100,000 опцион хэрэгжиж, 3,080,000 опционы хугацаа дууссан).

2023, 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

	2024.06.30		2023.06.30	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ
1 сарын 1-ний байдлаар	20,485,000	\$ 0.35	17,555,000	\$ 0.36
Олгосон	5,680,000	0.30	6,325,000	0.36
Хугацаа дууссан	(315,000)	0.39	(3,080,000)	0.40
Хэрэгжүүлсэн	(2,660,000)	0.23	(100,000)	0.20
6 сарын 30-ны байдлаар	23,190,000	\$ 0.35	20,700,000	\$ 0.35
6 сарын 30-ны байдлаар хэрэгжүүлэх боломжтой	23,190,000	\$ 0.35	20,700,000	\$ 0.35

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("ИОХЭ" буюу "DSU")

2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын байдлаар компани нь ХСУБХ-ийн хүрээнд нэгж тус бүр нь дунджаар \$0.37 долларын бодит үнэ цэн бүхий 1,241,733 ширхэг ИОХЭ олгосон (2023 – \$0.37 дундаж үнэлгээ бүхий 360,918 ширхэг ИОХЭ). Бодит үнэлгээ нь \$461,672 (2023 – \$131,950) бүхий ИОХЭ нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан.

Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ. 2023 оны 6 сарын 22-нд батлагдсан хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн төлөвлөгөө дэх ИОХЭ-ийн нөхцлүүд нь хуучин хэрэгжиж байсан ИОХЭ-ийн хөтөлбөрийн заалтуудтай нийцэж байна.

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд ИОХЭ-ийн тоо ширхэг болон 5 хоногийн жигнэсэн дундаж ханшийн тухай мэдээллийг доор харуулав.

	2024.06.30	2023.06.30
	Тоо ширхэг	Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	8,442,250	7,287,272
Олгосон	1,241,733	360,918
6 сарын 30-ны байдлаар	9,683,983	7,648,190

	2024.06.30	2023.06.30
Олгогдсон өдрөөс тооцоолсон 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ	\$ 0.37	\$ 0.37

8. Хайгуул болон үнэлгээний зардал

2023, 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав ба зургаан сарын хугацаанд хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав:

	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2024	2023 Тохируулсан (Тодруулга 12)	2024	2023 Тохируулсан (Тодруулга 12)
Элэгдэл, хорогдол	\$ 1,368	\$ -	\$ 1,368	\$ -
Шууд зардал	122,373	(8,851)	298,085	22,281
Ажилтан, албан тушаалтнуудын урамшуулал	307,670	(10,949)	562,164	11,835
Хувьцаанд суурилсан урамшуулал	165,179	498,399	518,129	511,310
	\$ 596,590	\$ 478,599	\$ 1,379,746	\$ 545,426

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

9. Захиргаа, удирдлагын зардал

2023, 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав ба зургаан сарын хугацаанд захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг дор харуулав:

	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2024	2023	2024	2023
Захиргааны үйлчилгээ	\$ 260,275	\$ 385,168	\$ 678,017	\$ 565,339
Элэгдэл, хорогдол	8,887	9,214	17,910	18,594
ТУЗ-ийн гишүүдийн урамшуулал, нөхөн төлбөр	39,151	29,672	70,401	63,744
Санхүүжилтийн заердал	-	-	1,269,124	-
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	41,209	83,159	149,084	166,645
Оффис ба бусад	11,367	28,271	38,627	54,065
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	71,367	145,395	161,665	248,572
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардлууд	26,499	29,639	90,173	91,964
Хувьцаанд суурилсан урамшуулал	196,747	654,594	883,043	698,915
Томилолтын зардал	11,528	26,342	86,574	63,727
	\$ 667,030	\$ 1,391,454	\$ 3,444,618	\$ 1,971,565

10. Санхүүгийн хэрэглүүр

Зээлийн эрсдэл:

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь хамгийн өндөр зээлийн эрсдэлийг агуулдаг. Тайлангийн өдрөөр тасалбар болгон хамгийн өндөр зээлийн эрсдэлийг харуулбал:

	Дансны үнэ	
	6 сарын 30 2024	12 сарын 31 2023
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 3,027,494	\$ 4,349,599
Авлага	135,848	6,722
	\$ 3,163,342	\$ 4,356,321

Компани нь өөрийн бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн дийлэнх хэсгийг Канадын санхүүгийн байгууллагуудад байршуулж зээлийн эрсдэлийг удирддаг бөгөөд удирдлагын зүгээс алдагдал хүлээх эрсдэл бага гэж үздэг. 2024 оны 6 сарын 30-ны байдлаар \$92,499 доллар буюу бэлэн мөнгөний 3% нь Канадаас бусад банкуудад хадгалагдаж байсан (2023 - \$35,672 доллар буюу 1%).

Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

а) Хүүгийн эрсдэл

Компани нь илүүдэл бэлэн мөнгийг хүүтэй хадгаламжийн дансанд байршуулж байгаа нь хүүгийн эрсдэл үүсгэх магадлалтай.

б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллараар зардлыг гаргасан. Иймээс канад

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад Улсын банкнуудад канад болон ам.доллар байршуулдаг.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	6 сарын 30 2024	12 сарын 31 2023
Мөнгө ба түүнтэй адилтгах	\$ 583,598	\$ 1,050,778
Худалдаа, бусад өглөг	(19,697)	(5,949)
	\$ 563,901	\$ 1,044,829

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$56,400 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2023.12.31 - \$104,500).

Компанийн гадаад валют (монгол төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	6 сарын 30 2024	12 сарын 31 2023
Мөнгө ба түүнтэй адилтгах	\$ 7,841	\$ 876
Худалдаа, бусад авлага	14,867	2,138
Худалдаа, бусад өглөг	(439)	(18)
	\$ 22,269	\$ 2,996

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$2,200 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2023.12.31 - \$300).

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

Бодит үнэ цэн:

Бодит үнэ цэн нь тооцох өдөр зах зээлд оролцогчдын хооронд хийсэн хэлцлийн дагуу хөрөнгийг худалдахад хүлээн авах эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх үнэ юм. Бодит үнэ цэний түвшин нь бодит үнэ цэнийг ангилан хэмжихэд ашигласан үнэлгээнд тогтоодог:

а) Түвшин 1: Хөрөнгө болон өр төлбөрийн зах зээл дэх үнэ;

б) Түвшин 2: Түвшин 1-д тогтсон зах зээлийн үнээс бусад шууд болон шууд бусаар тогтоогдох үнэ;

с) Түвшин 3: Зах зээлийн үнээс үл хамаарсан байдлаар тогтоогдох үнэ

Дээрх хэрэгслүүдийн хугацаа нь богино хугацааны тул санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн нь дансны үнэ цэнтэй ойролцоо байна.

11. Холбогдох талууд

Компанийн голлох удирдах ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдах албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдах ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

	6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2024	2023
ТУЗ-ийн гишүүдийн урамшуулал, нөхөн төлбөр	\$ 61,500	\$ 85,500
Хувьцаанд суурилсан урамшуулал	491,000	414,800
Удирдах ажилтнуудын цалин, урамшуулал	1,131,422	989,893
Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан урамшуулал	562,018	377,265
	\$ 2,245,940	\$ 1,867,458

12. Өмнөх хугацааны тохируулга

2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайланг бэлтгэх явцад компани 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн турш Эрдэнэ Монгол ХХК-ийг 100% эзэмшиж байсан ба 2023 оны 1 сарын 10-нд ММС-тэй гүйцэтгэсэн гэрээг эцэслэснээр Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтыг шилжүүлсэн (Тодруулга 4-өөс дэлгэрэнгүй танилцана уу).

Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтыг шилжүүлснээр Эрдэнэ Монгол ХХК дахь хөрөнгө оруулалтыг компани нэгтгэхээ больсон. Гэвч, нөлөөлөл хэвээр байгаа тул компани Эрдэнэ Монгол ХХК дахь хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргаар тайлагнадаг. Үүнтэй зэрэгцэн, санхүүгийн тайлангийн толилуулгын өөрчлөлтөөс үүдэн санхүүгийн тайлант хугацааны зарим харьцуулсан тооцооллыг шинэчилсэн.

2023 оны турш компанийн Эрдэнэ Монгол ХХК дахь эдийн засгийн өмчлөлд өөрчлөлт ороогүй тул дээрх өөрчлөлтийн цэвэр нөлөө нь хяналт шилжсэнээс хүлээн зөвшөөрөгдсөн мөнгөн бус орлогоор хязгаарлагдаж байгаа ба материаллаг гэж тооцогдоогүй. Доорх хүснэгтэд Эрдэнэ Монгол ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар нэгтгэн тайлагнасан болон санхүүгийн тайлангийн толилуулгын өөрчлөлтийн дүнд өмнөх жилийн үлдэгдлийг толилуулсан өөрчлөлтийг нэгтгэн харуулав. (Тэмдэглэл: Доорх хүснэгт дэх дүнг бүхэлдсэн тул тооцооллын зөрүү үүсэх магадлалтай.)

Завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

2023.06.30-ны байдлаар	Өмнө мэдээлсэн	Өмнөх үеийн тохируулга	Дахин тохируулга хийсэн
Эргэлтийн хөрөнгө	\$ 13,943,396	\$ (7,516,061)	\$ 6,427,335
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	51,811,966	51,811,966
Бусад эргэлтийн бус хөрөнгө	48,821,737	(46,554,296)	2,267,441
Богино хугацаат өр төлбөр	14,190,312	(13,914,150)	276,162
Урт хугацаат өр төлбөр	5,824	-	5,824
Цэвэр хөрөнгө	48,568,997	11,655,759	60,224,756

Завсрын үеийн нэгтгэсэн алдагдлын хураангуй тайлан

2023.06.30-ны байдлаар	Өмнө мэдээлсэн	Өмнөх үеийн тохируулга	Дахин тохируулга хийсэн
Үйл ажиллагааны зардал	\$ 3,524,926	\$ (1,007,935)	\$ 2,516,991
Цэвэр (орлого) алдагдал	3,646,518	(6,544,863)	(2,898,346)
Бусад дэлгэрэнгүй (орлого) алдагдал	639,065	(5,110,896)	(4,471,831)
Нийт дэлгэрэнгүй (орлого) алдагдал	4,285,583	(11,655,759)	(7,370,177)
Нэгж хувьцаанд ногдох суурь (орлого) алдагдал	\$ 0.01	\$ (0.02)	\$ (0.01)

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2023 болон 2024 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн тайлан

Завсрын үеийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн хураангуй тайлан

2023.06.30-ны байдлаар	Өмнө мэдээлсэн	Өмнөх үеийн тохируулга	Дахин тодруулга хийсэн
Хувьцаат капитал	\$ 157,911,469	\$ -	\$ 157,911,469
Нэмж төлөгдсөн капитал	29,926,022	-	29,926,022
Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	(6,592,051)	5,110,896	(1,481,155)
Алдагдал	(132,676,443)	6,544,863	(126,131,579)
Нийт эздийн өмч	\$ 48,568,997	\$ 11,655,759	\$ 60,224,757

Завсрын үеийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний хураангуй тайлан

2023.06.30-ны байдлаар	Өмнө мэдээлсэн	Өмнөх үеийн тохируулга	Дахин тохируулга хийсэн
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	\$ (3,446,018)	\$ 1,975,998	\$ (1,470,020)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	14,023,568	(14,019,610)	3,958
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(5,533,768)	4,479,803	(1,053,965)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)	4,833,212	(7,365,609)	(2,532,397)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны сүүлд	\$ 12,254,812	\$ (7,365,609)	\$ 4,889,203

Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.